

ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, ЦАЛИН ХӨЛСНИЙ ХЭЛТСИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ, ЦАЛИН ХӨЛС,
НИЙГМИЙН БАТАЛГААНЫ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
О.МЯГМАРСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Төрийн албаны ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл боловсруулна.							
1.	Арга хэмжээ 1.1. Төрийн албаны ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулна.	Тогтоолын төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь	100%	100%	Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэснээр төрийн нийтлэг үйлчилгээний албан тушаалд хамаарч буй архивын салбарын албан хаагчид (1911), цаг уур, орчны шинжилгээний салбарын албан хаагчид (1893), Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори (443), мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори (280) зэрэг лабораторийн албан хаагчид, нягтлан бодогч (2700), нийгмийн хамгааллын байгууллагын (84) нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, арга зүйч, багш, бүлгийн багш, нийт 7311 албан хаагчийг 2024 оны 04	2024.01.02-2024.12.31	100%

				дүгээр 01-ний өдрөөс ажлын онцлог, нөхцөлөөс хамааруулан төрийн мэргэжлийн үйлчилгээний албан тушаалд шилжүүллээ. Уг арга хэмжээнд 9.0 тэрбум төгрөг зарцуулсан. Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан, Засгийн газрын 2024 оны 138 дугаар тогтоолоор батлуулав. Ингэснээр Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар “Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс”-ийг “Нийгмийн даатгалын газар” байхаар, мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс”-ыг “Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл”, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс”-ыг “Эрүүл мэндийн магадлалын зөвлөл” болгон нэр өөрчлөн хуульчилсантай холбогдуулан холбогдох өөрчилөлтийг оруулсан. Мөн дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга, хэлтсийн даргын албан тушаалын зэрэглэлийг аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын албан тушаалтай нэг зэрэглэлд баталсан. Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан, Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолоор батлуулав. Уг тогтоолоор “Шинэ Зуунмод хотын захирагчийн ажлын алба”-ны албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоосон.		
--	--	--	--	--	--	--

Зорилт 2. Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар хууль тогтоомжийн төсөл боловсруулна.							
2.	Арга хэмжээ 2.1. Төрийн албан хаагчийн цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх талаарх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулна.	Тогтоолын төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь	100%	100%	Засгийн газрын 2024.03.27-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэн тогтоов. Уг арга хэмжээнд 532.4 тэрбум төгрөг зарцуулсан .	2024.01.02-2024.12.31	100%
Зорилт 3. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах талаар хууль тогтоомжийн төсөл боловсруулна.							
3	Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа /нэмэгдэл, тусламж, тэтгэмж, урамшуулал/ хангах талаарх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулна.	Тогтоолын төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь	100%	100%	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаатай холбоотой дараах тогтоол, шийдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Үүнд: 1. Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батлуулав. Журам батлагдсанаар Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгож эхлээд байна. Ингэснээр сум, алслагдсан дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэж, амьдралын нөхцөл, чанараа дээшлүүлэхэд нь тодорхой санхүүгийн дэмжлэг болох бөгөөд тав ба түүнээс дээш жил ажилласан 3.9 мянган албан хаагчид урамшуулал олгоход 2024 онд Улсын төсвөөс	2024.01.02-2024.12.31	100%

				59.4 тэрбум төгрөг зарцуулсан. 2. Засгийн газрын 2024 оны 02 дугаар 28-ны өдрийн 82 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төв болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгохоор холбогдох журмыг шинэчлэн батлуулсан. Журам батлагдсанаар өмнө нь орон нутгийн нэмэгдэл авдаггүй байсан шинжлэх ухаан зэрэг төрийн мэргэжлийн үйлчилгээний зарим албан хаагчид, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг шинээр авч эхэлснээр төрийн үйлчилгээний нийт албан хаагчид орон нутгийн нэмэгдэл авах боломжтой болсон. Мөн улс төрийн албан тушаал эрхэлдэг албан хаагчид уг нэмэгдлийг шинээр авч байна. Уг арга хэмжээнд нийт 105.2 мянган төрийн албан хаагчид хамрагдсан бөгөөд улсын төсвөөс 308.0 тэрбум төгрөг зарцуулсан. Мөн тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэх боломжтой болсон. 2024 онд орон нутгийн төсвөөс олгох нэмэгдлийн хувьд 20 хувиас дээш нэмэгдлийг нийт 14 аймаг олгож байна. Тухайлбал,		
--	--	--	--	--	--	--

				Говьсүмбэр аймаг 100 хувь, Өмнөговь аймаг 80 хувь, Орхон аймаг 60 хувь, Сэлэнгэ, Ховд аймаг 50 хувь, Баянхонгор, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв аймаг 40 хувь гэх мэт. 3. Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 12 дугаар тогтоолоор "Журам батлах тухай" Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-д нэмэлт оруулж, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймаг, нийслэлийн зоонозын өвчин судлалын төвд ажиллаж байгаа зарим албан хаагчид нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиар олгохоор тогтоосон. 4. Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 98 дугаар тогтоолоор "Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-ыг батлуулсан. Журам батлагдсанаар нэг алба хаагчид жилд дунджаар 1.118.867-1.614.960 төгрөгийн нэмэгдлийг нэмж олгох бөгөөд жилд нийт 1.06 тэрбум төгрөг зарцуулсан. 5. Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор "Аймаг, сумын нутаг дэвсгэр хариуцсан шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг батлуулсан. Журам батлагдсанаар Шүүх шинжилгээний байгууллагын хэмжээнд орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажилласан 115 алба хаагч 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж авахад улсын		
--	--	--	--	--	--	--

				төсвөөс 4.0 орчим тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд цаашид тус байгууллагын алба хаагчид уг тэтгэмжийг авах болзол шаардлага хангасан тухай бүртээ авах боломж болсон. 6. Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 160 дугаар тогтоолоор “Журам, хэмжээ батлах тухай” (Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, хэмжээ”) Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан. Энэ арга хэмжээний хүрээнд төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд 245 албан хаагч шилжсэнээр бүтэн 310 орон тоогоор ажиллахад жилд дунджаар 11.5 тэрбум төгрөг зарцуулсан. 7. Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 257 дугаар тогтоолоор “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, “Дотоодын цэргийн алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэн батлуулсан. Ингэснээр дотоодын цэргийн алба хаагчид тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг шинээр авч эхлэх бөгөөд 2024 онд аймгийн төвөөс бусад суманд үүрэг гүйцэтгэж байгаа дотоодын цэргийн 26 алба хаагч урамшуулал авахад улсын төсвөөс 804.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд цаашид цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид уг урамшууллыг авах		
--	--	--	--	---	--	--

				болзол шаардлага хангасан тухай бүртээ авах боломж болсон. Мөн дотоодын цэргийн алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 5 хувиар нэмэгдүүлж, 25 хувиар олгохоор болсон. Мөн Дотоодын цэргийн нийт 55 алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 5 хувиар нэмэгдүүлж, 25 хувиар олгоход дунджаар сард 4.1, жилд 49.7 сая төгрөг зарцуулна. 8. Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 259 дүгээр тогтоолоор “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид нэмэгдэл олгох журмыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолыг хэлэлцүүлэн батлуулав. Уг тогтоолоор ”Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид ялтан, хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг тус тус баталсан. Ингэснээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг болж, нэг алба хаагчийн нэмэгдлийн хэмжээ сард дунджаар 265.6-372.1 мянган төгрөгөөр нэмэгдэнэ. 9. Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Зэвсэгт хүчин, хилийн цэргийн алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг шинэчлэн батлуулав. Уг арга хэмжээний үр дүнд зэвсэгт хүчин, хилийн цэргийн алба хаагчдын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ дотоодын цэрэг, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх		
--	--	--	--	---	--	--

				байгууллагын алба хаагч зэрэг тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг бусад байгууллагын алба хаагчтай адил түвшинд болж, 15 хувиар нэмэгдсэн. 10.“Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн цолны нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 202 дугаар тогтоолоор батлуулсан. Ингэснээр цагдаа, дотоодын цэргийн алба хаагч цолны нэмэгдлийг бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай адил түвшинд, цол бүрээр ялгамжтай авахаар болж, алба хаагчдын цолны үнэлэмж нэмэгдсэн. 11."Алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарын алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын төслийг Батлан хамгаалах яамтай хамтран боловсруулж, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 201 дүгээр тогтоолоор батлуулсан. Журам батлагдсанаар алслагдсанд тооцох цэргийн анги, салбаруудад Засгийн газрын 2018 оны н/365 тогтоолын дагуу 2 цэргийн анги, 14 салбар, 2023 оны н/123 дугаар тогтоолоор 1 анги, 5 салбар, нийт Зэвсэгт хүчний 3 анги, 19 салбар хамрагдаж байгаагаас тав ба түүнээс дээш жилийн хугацаагаар тасралтгүй алба хаасан 170 орчим цэргийн алба хаагч уг нэмэгдлийг авах боломжтой болсон. Цаашид Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”-ын гол зорилтуудын нэг болох Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбаруудад үүрэг гүйцэтгэн тав ба түүнээс дээш жил ажиллаж байгаа алба хаагчдад уг мөнгөн урамшууллыг олгох бөгөөд ингэснээр тогтвор суурьшилтай ажиллуулах, байнгын бие бүрэлдэхүүний		
--	--	--	--	--	--	--

				шилжилт хөдөлгөөн буурах, тэдний ар гэр, амьдралд эдийн засгийн томоохон дэмжлэг болно. 12."Шалгуур үзүүлэлт батлах тухай" /"Төсвийн байгууллагын нягтлан бодогчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"/ Сангийн сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/24, А/13 дугаар хамтарсан тушаал. 13. "Шалгуур үзүүлэлт батлах тухай" /"Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"/ Соёлын сайд, САНгийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/166, А/63, А/73 дугаар хамтарсан тушаал. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаатай холбоотой дараах тогтоол, шийдвэрийн төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, яамд болон холбогдох газруудаас санал авч, ирүүлсэн саналыг тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Үүнд: 1.Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхэд бэлэн болоод байна. Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулснаар цэцэрлэг, ерөнхий боловсролын		
--	--	--	--	--	--	--

				сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх шалгуур тодорхой болох, цэцэрлэг, сургуулийн зөвлөл, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн оролцоо нэмэгдэж үнэлгээ бодитой хийгдэн тухайн түвшний сургалтын байгууллагын үйлчилгээний чанар сайжирна гэж үзэж байна. 2.“Цэргийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Батлан хамгаалах яамтай хамтран боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхэд бэлэн болоод байна. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн нэмэгдлийн хэмжээг цэргийн байгууллагуудын мөрдөж байгаа хувь хэмжээтэй адилтган тогтоосноор батлан хамгаалах, зэвсэгт хүчний болон хил хамгаалах байгууллагын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчдын албандаа хандах хандлага сайжирч, тэдний нийгмийн хамгаалал тодорхой түвшинд дээшлэх ач холбогдолтой. Төрийн албан хаагчийн нийгмийн батлагааг хангахтай холбоотой эрх бүхий байгууллагуудаас боловсруулан санал авахаар ирүүлсэн дараах хууль, Засгийн газрын тогтоол, хамтарсан тушаалын төсөлд санал боловсруулан хүргүүлэв. Үүнд: 1.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл. 3.Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын		
--	--	--	--	---	--	--

					эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 4.“Журам батлах тухай” /Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”/ Засгийн газрын тогтоолын төсөл. 5.“Журам батлах тухай” /“Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”/ Засгийн газрын тогтоолын төсөл. 6.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл. 7.”Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн тогтоолын төсөл. 8.”Шалгуур үзүүлэлт батлах тухай” /”Стандарт, хэмжил зүйн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт батлах тухай”/ хамтарсан тушаалын төсөл.		
Зорилт 4. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны нэгдсэн тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.							
4.	Арга хэмжээ 4.1. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл боловсруулна.	Хуулийн төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь	0%	100%	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/126 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийг үзэл баримтлалын төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлахаар 2024 оны 03 дугаар	2024.01.02-2024.12.31	100%

				сарын 22-ний өдрийн 01/740 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулаад байна. Мөн Хуулийн төсөлтэй холбогдуулан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 33 хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгох тухай хуулийн төсөл боловсруулаад байна. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/741 тоот албан бичгээр яамд болон холбогдох байгууллагуудаас санал авч, ирүүлсэн саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусгаад байна. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа болон хуулийн төслийн танилцуулгыг Засгийн газрын 3 удаагийн хуралдаанд танилцуулсан. Мөн хуулийн төслийн хэлэлцүүлгийг Удирдлагын академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчдын төлөөллийг хамруулан 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын албан хаагчдын төлөөллийг хамруулан 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, яам, агентлагуудын удирдах, гүйцэтгэх албан хаагчид, нутгийн захиргааны байгууллагуудын удирдах, гүйцэтгэх, нийт 1600 албан хаагчид 16 удаагийн хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 21-нээс 31-ний өдрүүдэд танхимаар болон цахимаар зохион байгуулсан. Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гарагийн 10 цагаас зохион байгуулдаг “7:4:10” сургалтын 2024 оны 05 дугаар сарын 16-ны		
--	--	--	--	--	--	--

				өдрийн ээлжит сургалтад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа” сэдвээр мэдээлэл өгч, хуулийн төслийг танилцуулсан. Уг вебинарт 3500 гаруй төрийн албан хаагч оролцож, танилцуулга, мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авсан. Хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн эрэмбэлж, хуулийн төсөлд тусгаад байна.		
--	--	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тухай төрийн болон бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын холбогдох албан тушаалтнуудад чиглэл, зөвлөмж мэдээлэл өгөх.	Хуульд нийцсэн үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, чиглэл, зөвлөгөө	100%	100%	Засгийн газрын 2024 оны 82, 83, 84 дүгээр тогтоол болон бусад төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой Засгийн газрын шийдвэрийн талаар мэдээлэл, зөвлөмж авахыг хүссэн иргэд, байгууллагуудыг мэдээлэл, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллав. Энэ хүрээнд: - 260 албан бичиг ирсэн бөгөөд хариутай бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, зохих хариуг хүргүүлсан. - Иргэдээс гаргасан 145 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хариуг өгсөн. - Мөн иргэд, байгууллагуудаас мэдээлэл зөвлөгөө авахаар утсаар холбогдсон тухай бүр хариу өгч ажиллав. - Төрийн албаны зөвлөлийн ээлжит 7:4:10 арга зүйн вэбинар сургалт, мэдээллийн цагт зочноор оролцож, “Төрийн албан хаагчийн цалин хөлс” /Орон нутгийн нэмэгдэл/ сэдвээр мэдээлэл өгч, төрийн албан хаагчдын асуултад хариулсан.	2024.01.02-2024.12.31	100%

2.	Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 2. Хууль тогтоомжийн хэрэгжилт, Монгол Улсыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг болон бусад холбогдох баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээний биелэлт, явцын талаарх мэдээллийг хуулийн хугацаанд багтаан яамны холбогдох газар, хэлтэст гаргаж өгөх.	Хууль тогтоомжийн хэрэгжилт, Монгол Улсыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийн биелэлт, хэрэгжилтийн талаар мэдээлэл	100%	100%	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө /Үндсэн чиглэл/, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг сар бүр, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг хуулийн хугацаанд нь тус тус гарган Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.	2024.01.02-2024.12.31	100%
----	---	---	------	------	---	-----------------------	------

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах.	Сертификат, гэрчилгээ	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан	100%	Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн вэбинар сургалтуудад хамрагдав. Үүнд: 1. 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн “Төрийн албан хаагчийн үнэт зүйл (эрхэмж), үе хоорондын ялгаатай байдал”; 2. 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа”; 3. 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь”	2024.01.02-2024.12.31	100%

				4. 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр ОУ-ын илтгэгч, Кэмбриджийн их сургуулийн багш, Олимпийн тамирчин, дипломатч Кэйт Бишопын "Гүйцэтгэлийг сайжруулах, соёлыг өөрчлөх, үр дүнтэй баг болон манлайлагчийг хөгжүүлэх нь" сэдэвт лекц; 5. 2024 оны 11 дүгээр сарын 01-14-ны өдрүүдэд БНХАУ-ын Жиансу мужийн Тайкан хотод зохион байгуулагдсан "Хөгжиж буй орнуудын хүн ам ба тогтвортой хөгжил" сэдэвт семинар; 6. 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр "Soft skills-Хувь хүний үр чадвар" сэдэвт сургалт.		
--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХБГ-ын ХХЦХХ-ийн шинжээч

(Албан тушаал)

 /О.Мягмарсүрэн/

 (Нэр, гарын үсэг)

2024-12-01
 (Огноо)